

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ УДААШРАХ,
ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛ ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ БАЙНА.

БУЛГАН АЙМАГ 2022 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Содном
Утас: 70342716 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор З.Ганбаатар
Утас: 70342716 Цахим хаяг: Ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1.УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	8
A.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.....	8
A.1.1 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ 4866.7 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээнээс бусад төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.....	8
A.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнээс ТЕЗ-аас санал хүргүүлээгүй төсөл арга хэмжээ туссан байна.....	8
A.1.3 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна.....	9
A.2 Булган аймагт 2021 онд эрх шилжиж ирсэн шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнээс зураг төсөвт магадлал хийлгэх шаардлагатай төсөл арга хэмжээ байхгүй байна.....	9
A.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.....	10
A.3.1 Шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангасан төсөл арга хэмжээнүүд байна.....	10
A.3.2 Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.....	10
A.3.3 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжгүйгээр баталсан байна.....	11
A.3.4 Хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, батлуулсан байна.....	11
БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ИХЭНХ НЬ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БОЛОВЧ ЗАРИМ ХӨРӨНГИЙГ, АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	11
B.1 Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	12
B.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.....	12
B.1.2. ХАА-г төлөвлөгөөнөөс хоцорч зохион байгуулсан ч тайлант хугацаандаа хэрэгжсэн байна.....	13
B.1.3. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулжээ.	14
B.1.4. Гүйцэтгэчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.	14
B.1.5 Аймгийн Орон нутгийн өмчийн газар худалдан авах ажиллагааны тайланг гаргаж, хугацаанд нь тайлагнасан.....	15
B.2. Б.2 Тайлант онд 4 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргад эрх шилжүүлж, бүрэн хэрэгжсэн байна.....	15
B.2.1. Эрх шилжсэн он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнээс гэрээг сунгасан 5 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 64-82 хувьтай байна.....	15

Б.2.2. Захиалагч, зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд арилгах арга хэмжээ авсан байна.	16
Б.2.3 Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжийг данс бүртгэлд туссан ч эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон тоног төхөөрөмжийг эзэнжүүлэх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна.....	17
Б.2.4 Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон барилга, байгууламж, нийлүүлээгүй техник, тоног төхөөрөмж байхгүй байна.	17
Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	17
Б.3.1. Захиалагч, зохиогчийн зүгээс үе шатны ажлыг тухай бүр хянаж илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар талбайн журналд тэмдэглэн хянаж, ил ба далд ажлын гүйцэтгэлийг актаар баталгаажуулсан байна.	18
Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь бүрэн олгосон байна.	18
Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад дотоодын хяналт тавих чиг үүрэг хэрэгжихгүй байна.....	18
Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилийн санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр үр дүнтэй байна.....	19
Б.4.1 Төлбөрийн баталгаа болон бусад үндэслэлээр ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд 6 төсөл арга хэмжээний 718.6 сая төгрөгийг байршуулан төсөл,арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.....	20
Б.4.2 Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгоогүй байна.	20
Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хийгдсэн зарим ажлын үр дүнг тооцоогүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.....	21
Б.5.1 Шинэ-хөдөө төслийн 2021 оны хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжийг иргэн, ААН байгууллагатай эргэн төлөлт болон ашиглалтын гэрээ хийж ажиллаагүй, бусад хэрэгжсэн төсөл арга хэмжээ зориулалтын дагуу ашиглалт хэвийн байна.....	21
Б.5.2 Шинээр хэрэгжиж байгаа болон он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 2021 онд өөрчлөлт орсон ажил байхгүй байна.....	21
Б.5.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс төлөвлөлттэй холбоотой зөрчил давтан гарсан байна.	
Б.5.4 . Улсын төсвийн санхүүжилтээр ажлын байрыг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, арга хэрэгжүүлсэн ч үр дүн хангалтгүй байна.....	21
Б.5.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийгдсэн байна.....	21
Холбогдох байгууллагын санал:.....	22
Саналд өгсөн тайлбар:.....	22
Дүгнэлт:	23
САНАЛ:	24
ЗӨВЛӨМЖ:	25
ТУШААЛ:	26
АЛБАН ШААРДЛАГА.....	27

Товчилсон үгийн тайлбар

УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БХБ	Барилга хот байгуулалт
БХТ	Барилга хөгжлийн төв
ЗТБХБГ	Зам тээвэр барилга хот байгуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш зураг төсөв хийсэн төсөл, арга хэмжээ	8-9
Хүснэгт 2	Төсөл арга хэмжээний санхүүжилт	9
Хүснэгт 3	ХАА-ны хэрэгжилт	15
Хүснэгт 4	Гэрээ сунгасан төсөл, арга хэмжээ	
Хүснэгт 5	Эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл	
Хүснэгт 6	Тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэгдсэн эсэх	
Хүснэгт 7	Төсөл арга хэмжээний барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан үлдэгдэл	
Хүснэгт 8	Шинээр ашиглалтад орсон, барилга, тоног төхөөрөмж	

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Эрх шилжээгүй ТАХ нэр төрлөөр	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 тушаалаар баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж дүнг Үндсэний аудитын газарт хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцууллага иргэд олон нийтэд мэдээлэхэд зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд эрх шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв болон бусад байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллагын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, аудитын аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Содном, аудитор З.Ганбаатар нар хийж гүйцэтгэлээ. Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2022 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл ажлын 21 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр УАГ-т, аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т тус тус хүргүүлэн ажилласан болно.

Хүндрэл бэрхшээл

Аудит хийх ажлын хоног боломжийн боловч санхүүгийн аудит болон судалгааны ажилтай байсан тул зарим үед ажлын ачаалал их байсан,

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 47,658.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс өмнөх оноос шилжиж ирсэн 6, шинээр хэрэгжих 21, БШУЯ-ны багцаас сургуулийн их засварын 2 нийт 29 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.


Аймагт 2021 онд 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 тоног төхөөрөмж, БШУЯ-ны багцаас 150 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 сургуулийн их засварын ажлыг эрх шилжүүлсэн байна.

- Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Булган, Булган сум/
- Шинэ хөдөө төсөл /Булган/
- Хишиг-Өндөр сумын сургуулийн их засвар БШУ сайдын багцаас
- Гурванбулаг сумын Сургуулийн их засвар БШУ сайдын багцаас зэрэг төсөл арга хэмжээнүүд эрх шилжиж ирсэн байна.

Эрх шилжээгүй шинээр хэрэгжих 17 төсөл арга хэмжээний 7 арга хэмжээ буюу 41.2 хувийг барилга байгууламж, 4 арга хэмжээ буюу 23.5 хувийг их засварын ажилд, 2 арга хэмжээ буюу 11.8 хувийг тоног төхөөрөмж, 2 буюу 11.8 хувийг авто зам, 2 арга хэмжээ буюу 11.8 хувийг эрчим хүч холбох ажилд тус тус зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Дүрслэл № 1 “Эрх шилжээгүй ТАХ нэр

төрлөөр”



Орон нутагт эрх шилжээгүй төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээний 7 ажил бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн, 4 төсөл арга хэмжээний ажил эхлээгүй, 4 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Төсөл арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй дараах 4 төсөл байна.

- ✓ Ахмадын сувиллын барилга /Булган, Хишиг-Өндөр сум/
- ✓ Сум дундын сургуулиудын хүүхдийн зуслан /Булган, Хишиг-Өндөр сум/
- ✓ Сумдад хүүхдийн тоглоомын талбай байгуулах /Булган/
- ✓ Нийтийн халуун усны барилга /Булган, Хишиг-Өндөр, Баяннуур сум/

Дараах 4 төсөл арга хэмжээний хугацаа сунгасан байна.

- Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/
- Үерийн далан /Булган, Сайхан сум/
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/
- Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/

Он дамжин хэрэгжих 4 төсөл арга хэмжээний 5 ажлын гүйцэтгэл 29-90 хувийн гүйцэтгэлтэй ажлууд байна.

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ 4866.7 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээнээс бусад төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан Булган аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2021 оны 04 тогтоолоор, аймгийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолоор баталжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 47,658.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс өмнөх оноос шилжиж ирсэн 6, шинээр хэрэгжих 21, БШУЯ-ны багцаас сургуулийн их засварын 2 нийт 29 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймагт 2021 онд 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 тоног төхөөрөмж, БШУЯ-ны багцаас 150 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 сургуулийн их засварын ажлыг эрх шилжүүлсэн байна.

Дараах төсөл арга хэмжээ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй ч УТХО-ын жагсаалтад батлагдсантай холбоотой тухайн жилийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих 439 дүгээр хаалттай ангийн спорт заалны барилга /Булган/
- Ахмадын сувиллын барилга /Булган, Хишиг-Өндөр сум/
- Нийтийн халуун усны барилга /Булган, Хишиг-Өндөр, Баяннуур сум/
- Сум дундын сургуулиудын хүүхдийн зуслан /Булган, Хишиг-Өндөр сум/

Дээрх 4866.7 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээнээс бусад 25 төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.

А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнээс ТЕЗ-аас санал хүргүүлээгүй төсөл арга хэмжээ туссан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.3¹ дахь заалтын дагуу захиалагчдын саналд үндэслэсэн байх шаардлагатай.

Аймгийн Засаг дарга УТХО-ын төлөвлөгөөнд тусгуулахаар 180,413.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 төсөл арга хэмжээний саналыг холбогдох яамдад хүргүүлжээ. Эрэмбэлж хүргүүлсэн төсөл, арга хэмжээнээс 19505.2 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээ батлагдсан байна.

Үүнээс орон нутгаас санал хүргүүлээгүй, холбогдох судалгаа, тооцоолол хийгдсэн эсэх нь тодорхойгүй 5,750.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ төсөвт батлагдсан байна. Үүнд:

¹ 3.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2-т заасан төслийг төсөвт тусгуулах саналыг албан бичгээр болон цахим системээр дамжуулан Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

- ✓ Ахмадын сувиллын барилга /Булган, Хишиг-Өндөр сум/
- ✓ Сум дундын сургуулиудын хүүхдийн зуслан /Булган, Хишиг-Өндөр сум/
- ✓ Сумдад хүүхдийн тоглоомын талбай байгуулах /Булган/
- ✓ Нийтийн халуун усны барилга /Булган, Хишиг-Өндөр, Баяннуур сум/

Дээрх төсөл арга хэмжээг хэрхэн төлөвлөсөн талаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс тодруулахад УИХ-ын гишүүний санаачилгаар тусган хэрэгжүүлж байгаа гэсэн албан бичгийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “хөрөнгө оруулалтын төслийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч бэлтгэж үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 8.4.3-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

А.1.3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна.

Улсын төсвөөр 2021 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.2.3²-д заасны дагуу Аймгийн ТЭЗ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцон эрэмбэлсэн байх шаардлагатай.

Булган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгуулах саналыг орон нутаг болон холбогдох байгууллагууд ирүүлсэн байна. Төсөл арга хэмжээг эрэмбэлсэн эсэхийг үзэхэд аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж эрэмбэлэн төсөл, арга хэмжээний саналыг холбогдох яамдад хүргүүлсэн ч хэрэгцээ шаардлага, нийгмийн үр ашиг, ач холбогдлыг тодорхойлсон баримт материал байхгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн мэдээллийг pimis.publicinvestment.gov.mn цахим системээр 2019 оноос эхлэн гүйцэтгэсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгасан төсөл, арга хэмжээ бүрээр хийсэн судалгаа, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тооцоолол, холбогдох мэдээллийг агуулсан мэдээллийн цахим сан үүсгэх шаардлагатай байна.

А.2. Булган аймагт 2021 онд эрх шилжиж ирсэн шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнээс зураг төсөвт магадлал хийлгэх шаардлагатай төсөл арга хэмжээ байхгүй байна.

Барилгын тухай хуулиар зураг төсөл боловсруулахад эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх шаардлагатай.

Булган аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2021 онд шинээр хэрэгжих аймгийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, Соёлын төвийн тоног төхөөрөмж бэлтгэх, БШУЯ-наас эрх шилжүүлсэн 2 сургуулийн их засвар нийт 4 төсөл арга хэрэгжүүлсэн нь ЗГ-ын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, магадлал хийх дүрэм”-ээр магадлал хийлгэх шаардлагагүй ажлууд байна.

² энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төслийн саналыг улсын төсөвт тусгуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

БШУС-ын багцаас 2021 онд эрх шилжиж ирсэн 2 сургуулийн их засварын ажлаас Хишиг-Өндөр сумын сургуулийн их засварын ажлын зураг төсвийг “Аслаан” ХХК-иар 3.7 сая төгрөгөөр зураг төсөв хийлгэх гэрээг байгуулж санхүүжилтийг олгосон, харин Гурванбулаг сумын сургуулийн их засварын ажлыг 2009 оны зургаас ажлын тоо хэмжээг авч төсөв хийлгэж, халаах хэрэгсэл сольсон байна.

А.3. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

А.3.1. Шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангасан төсөл арга хэмжээнүүд байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд хэрэгжиж буй төсөл арга хэмжээнээс 120 ортой Цэцэрлэгийн барилга /Булган, Хутаг-Өндөр/, 240 суудал Соёлын төвийн барилга /Булган, Бугат сум/ зэрэг 2 барилга, соёлын төвийн тоног төхөөрөмж, нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжөөс бусад төсөл арга хэмжээ нь их засварын ажил байна.

Хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодруулахад:

- Бугат сумын 3-р багт байршилтай 200 хүний суудалтай 1987 онд ашиглалтад орсон дүнгэн хийцтэй, зориулалтын бус, инженерийн төвлөрсөн хангамжтай. Тус барилга нь засвар хийсэн боловч ашиглах боломжгүй гэсэн мэргэжлийн хяналтын дүгнэлт гарсан тул үйл ажиллагаагаа зогсоосон, шинээр 240 суудал Соёлын төвийн барилга барих шаардлага үүссэн байна.
- Хутаг-өндөр сумын төвийн 1-р багийн нутагт байршилтай 125 хүүхдийн хүчин чадалтай “Гацуурхан” цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг, сумын хэмжээнд 447 гаруй хүүхэд СӨБ-д хамрагдахаас хичээлийн байрны хүрэлцээ муутайгаас 153 гаруй хүүхдийг одоогоор хамруулж байна.

Шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангасан төсөл арга хэмжээнүүд байна.

А.3.2. Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зураг төсөл нь батлагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4⁴, Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам”-ын 3.2.1⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Хүснэгт №1 “Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш зураг төсөв хийсэн төсөл, арга хэмжээ”

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зураг төсөл боловсруулж		Гүйцэтгэгч байгууллага
			Эхэлсэн огноо	Дууссан огноо	
1	Сургуулийн барилгын их засвар /Булган, Дашинчилэн сум/		2021.01.18	2021.03.15	"Аркосис" ХХК
2	Сургуулийн барилгын их засвар /Булган, Гурванбулаг сум/		2021.03.16	2021.04.02	"Дархан од нар" ХХК
3	Сургуулийн дотуур байрны барилгын их засвар /Булган 1		2021.03.02	2021.04.01	"Үндсэн төсөл" ХХК

³ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁴ 31.4.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.

⁶ 3.2.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

	дүгээр сургууль/				
4	Соёлын төвийн барилгын их засвар /Булган, Рашаант сум/		2021.03.02	2021.04.01	"Өлзий иш" ХХК
5	Соёлын төвийн барилгын их засвар /Булган, Хишиг-Өндөр сум/		2021.02.28	2021.04.05	"Оргил цахмаг констракшн" ХХК
6	Сумдад тоглоомын талбай байгуулах /Булган/		2021.02.05	2021.08.12	"Оргил цахмаг" ХХК
7	Ахмадын сувиллын барилга /Булган, Хишиг-Өндөр/				Зураг төсөвгүй, ажил эхлээгүй.
8	Нийтийн халуун усны барилга /Булган, Хишиг-Өндөр сум/				Зураг төсөвгүй, ажил эхлээгүй.
9	Нийтийн халуун усны барилга /Булган, Баяннуур сум/				Зураг төсөвгүй, ажил эхлээгүй.
10	Сумд дундын сургуулиудын хүүхдийн зуслан /Булган, Хишиг-Өндөр/				Зураг төсөвгүй, ажил эхлээгүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээ жагсаалтад батлагдсаар байгаа тул ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллан уг зөрчлийг давтан гаргахгүй төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээнд санал хүргүүлж байх шаардлагатай байна.

А.3.3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжгүйгээр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 29.3.5-д “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгахаар заасан.

Он дамжин хэрэгжих 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 29.3.5-д зааснаар төсвийг батлаагүй байна.

Хүснэгт №2 “Төсөл арга хэмжээний санхүүжилт”

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
			2020	2021		2020	2021
1	V.1.1.6	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	2020	2021	806.3	200	606.3
2	XII.1.39	Үерийн далан /Булган, Сайхан сум/	2020	2021	431.0	50	381.0
3	XIII.1.1.178	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	2020	2021	1,169.6	200	723.9
4	XI.1.1.3	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	2020	2021	925.0	300	665.0

Аудитын хамрах хүрээний шинээр эрх шилжиж ирсэн 325.0 сая төгрөгийн аймгийн Нэгдсэн эмнэлэг, Соёлын төвийн тоног төхөөрөмж, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумын сургуулийн их засвар гэсэн 4 төсөл арга хэмжээний санхүүжилт хугацаандаа олгогдон хийгдсэн байна.


А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, батлуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр эрх шилжсэн 4 төсөл, арга хэмжээ нь тоног төхөөрөмж, их засварын ажлуудад зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Эрх шилжээгүй шинээр хэрэгжих 17 төсөл арга хэмжээний 7 арга хэмжээ буюу 41.2 хувийг барилга байгууламж, 4 арга хэмжээ буюу 23.5 хувийг их засварын ажилд, 2 арга хэмжээ буюу 11.8 хувийг тоног төхөөрөмж, 2 буюу 11.8 хувийг авто зам, 2 арга хэмжээ буюу 11.8 хувийг эрчим хүч холбох ажилд тус тус зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

төрлөөр”

Дүрслэл № 1 “Эрх шилжээгүй ТАХ нэр



Эдгээр төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага гэж заасантай нийцэж байна.

БҮЛЭГ Б. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ИХЭНХ НЬ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БОЛОВЧ ЗАРИМ ХӨРӨНГИЙГ, АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-д төсвийн тухай хууль батлагдсан өдрөөс 60 хоногийн дотор шилжүүлэх журмын заалттай.

Хөрөнгө оруулалтаар 2021 онд 2 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн 2020 оны төсвийн тухай хууль батлагдсан өдрөөс хойших хугацаагаар тооцон үзэхэд Соёлын төвийн тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээг Соёлын сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/15, аймгийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж бэлтгэх ажлыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/82 дугаар тушаалаар тус тус эрх шилжүүлсэн нь 20-44 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

Энэ нь худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнөөс оройтож зохион байгуулах, худалдан авах ажиллагаа амжилтгүй болох, хугацаа сунгагдсан тохиолдолд төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх, он дамжих зэрэг эрсдэлийг үүсгэсэн байна.

Б.1.2. ХАА-г төлөвлөгөөнөөс хоцорч зохион байгуулсан ч тайлант хугацаандаа хэрэгжсэн байна.

Тендерийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас оройтож зарласнаас шалтгаалж гэрээ байгуулах хугацаа 90-95 хоногоор хойшилсон ч эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын ажлаас шинэ хөдөө төслийн 9-р багцын 76.8 сая төгрөгийн арга хэмжээний гэрээ 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд сунгаснаас бусад арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт № 3 “ХАА-ны хэрэгжилт”

№	Төсөл арга, хэмжээний нэр	Гэрээний			
		Төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног	Хэрэгжилт
1	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/	2021.03.16	2021.07.23	95	Дууссан
2	Аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Булган, Булган сум/	2021.03.15	2021.07.19	90	Дууссан
3	Шинэ хөдөө төсөл /Булган/	2021.08.05	2021.08.05	0	9 багц гэрээ сунгасан
4	Хишиг-Өндөр сумын сургуулийн их засвар БШУ сайдын багцаас	2021.06.14	2021.06.17	0	Дууссан
5	Гурванбулаг сумын Сургуулийн их засвар БШУ сайдын багцаас	2021.06.24	2021.06.24	0	Дууссан

Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах хугацаа хойшилсон нь холбогдох сайдын багцаас төсөл, арга хэмжээний эрхийг хугацаа хоцроож шилжүүлсэн, мөн тендерт оролцох аж ахуйн нэгж байхгүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болж дахин зарласан, холбоотой байна.

Б.1.3. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулжээ.

Тайлант онд УТХО-аар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог тухай бүр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан, үнэлгээний хороонд давхардсан тоогоор 5 тендерт нийт 25 хүн томилогдсоноос иргэний төлөөллөөр 1 хүн бүх тендер оролцсон, 3 ажлын тендер зарлах болон тендерийг үнэлэх явц 60-100 хувийн бүрэлдэхүүнтэй, бусад нь гишүүд бүрэн оролцсон байна.

Үнэлгээний хорооны гишүүд нь бүгд худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай ба журмын дагуу үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг бөглөж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.

Тендер шалгаруулалтын холбоотой мэдээлэл, тендерт оролцоход шаардлагатай бүрдүүлэх материал, урилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлж, Тендер шалгаруулалтыг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг www.tender.gov.mn, www.bulgan.gov.mn цахим сайт, өдөр тутмын хэвлэл болох монголын мэдээ сонин, олон нийтэд нээлттэй мэдээлж, тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулан, үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой,

товлосон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2013 оны 84-р тушаалаар батлагдсан “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Б.1.5 Аймгийн Орон нутгийн өмчийн газар худалдан авах ажиллагааны тайланг гаргаж, хугацаанд нь тайлагнасан.

Булган аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тайланг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, журам”-ын дагуу батлагдсан маягтаар болон бичмэл тайлангаар 2020 оны жилийн эцсийн тайланг 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 07 тоот, 2021 оны хагас жилийн тайланг 2021 оны 07 дугаар сарын 06-ны 193, жилийн эцсийн тайлан 2022 оны 01 дүгээр сарын 4-ний өдрийн 03 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлжээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 12 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан маягтын дагуу бэлтгэж баталсан байна. Худалдан авах ажиллагааны тайлан, үр дүнгийн талаарх мэдээллийг тухай бүр “tender.gov.mn”, худалдан авах ажиллагааны тайланг төсөл, арга хэмжээ бүрээр шилэн дансны цахим сайтад байршуулсан байна.

Б.2 Тайлант онд 4 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргад эрх шилжүүлж, бүрэн хэрэгжсэн байна.

Б.2.1 Эрх шилжсэн он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнээс гэрээг сунгасан 5 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 64-82 хувьтай байна.

Булган аймагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын талаар:

Булган аймагт 2020 оноос дамжин хэрэгжсэн 6151.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 ажил хэрэгжиж байгаагаас 2 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, шинэ хөдөө төслийн 9-р багцын 80.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж гэрээ сунгагдсан, бусад 5 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээ сунгагдсан ажлын гүйцэтгэл 64-82 хувьтай байна.

Он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнээс гүйцэтгэл дутуу, гэрээг сунгасан төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 4 “Гэрээ сунгасан төсөл, арга хэмжээ”

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Гэрээний дуусах хугацаа	Ажлын гүйцэтгэл
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	2020	2021	806.3	2022.06.30	64.7%
2	Үерийн далан /Булган, Сайхан сум/	2020	2021	431.0	2022.07.01	
3	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	2020	2021	1,169.6	2022.05.31	82%
4	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	2020	2021	925.0	7/1/2022	71.7%
5	Шинэ-хөдөө төслийн / 9-р багц тоног төхөөрөмж/	2020	2021	80.0	2022.05.01	0
	Дүн			3331.9		

Дээрх 5 төсөл арга хэмжээ нь гэрээний хугацаанд дуусах бүрэн боломжтой байна.

2021 онд аймгийн Засаг даргад 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж авах 2 төсөл арга хэмжээ, БШУС-ын багцаас 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын 2 төсөл арга хэмжээ эрх шилжиж хэрэгжсэн байна.

Хүснэгт № 5 “Тайлант онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл”

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хүлээн авсан
1	Аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Булган, Булган сум/	2021	2021	100.0	100.0	2021.10.19 Актын дугаар 15
2	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/	2021	2022	250.0	75.0	2021.12.13
3	Хишиг-өндөр сумын сургуулийн барилгын их засвар /БШУ-ны салбарын их засвар/	2021	2021	100.0	98.9	2021.10.07 11/2021
4	Гурванбулаг сумын сургуулийн барилгын их засвар /БШУ-ны салбарын их засвар/	2021	2021	50.0	50.0	2021.08.02 09/2021
	Дүн			500.0	323.9	

Дээрх төсөл арга хэмжээ нь гэрээний хугацаанд бүрэн хэрэгжиж, холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч санхүүгийн тайланд орлогод авсан байна.

Орон нутагт эрх шилжээгүй төсөл арга хэмжээний талаар:

Орон нутагт эрх шилжээгүй 16 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээний 7 ажил бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн, 4 төсөл арга хэмжээний ажил эхлээгүй, 4 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Ажлын гүйцэтгэл
			эхлэх	дуусах		
1	XIII.1.2.46	Сургуулийн барилгын их засвар /Булган, Дашинчилэн сум/	2021	2021	588.0	Бүрэн дууссан
2		Сургуулийн барилгын их засвар /Булган, Гурванбулаг сум/	2021	2021	379.7	Бүрэн дууссан
3	XIII.1.2.52	Сургуулийн дотуур байрны барилгын их засвар /Булган 1 дүгээр сургууль/	2021	2021	300.0	Бүрэн дууссан
4	XIX.2.9	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Гурванбулаг	2021	2021	249.4	Бүрэн дууссан
5		Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Хишиг-Өндөр	2021	2021	238.6	Бүрэн дууссан
6		Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Рашаант	2021	2021	253.4	Бүрэн дууссан
7		Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Сайхан сум/	2021	2021	1,000.0	Бүрэн дууссан
8	XI.4.1.11	Ахмадын сувиллын барилга /Булган, Хишиг-Өндөр/	2021	2022	1,250.0	Ажил эхлээгүй
9	XII.1.91	Нийтийн халуун усны барилга /Булган, Хишиг-Өндөр сум/	2021	2022	200.0	Ажил эхлээгүй
10		Нийтийн халуун усны барилга /Булган, Баяннуур сум/				Ажил эхлээгүй
11	XIII.1.1.27	Сумд дундын сургуулиудын хүүхдийн зуслан /Булган, Хишиг-Өндөр/	2021	2022	3,000.0	Ажил эхлээгүй
12	XIII.1.1.274	Цэцэрлэгийн барилга 120 ор /Булган, Хутаг-Өндөр/	2021	2022	994.4	Барилгын ажил 58 хувийн гүйцэтгэлтэй
13	XII.1.90	Сумдад тоглоомын талбай байгуулах /Булган/	2021	2022	1,300.0	Барилгын ажил 67 хувийн гүйцэтгэлтэй
14	XIV.1.58	Соёлын төвийн барилга, 240 суудал /Булган, Бугат сум/	2021	2022	1,595.5	Барилгын ажил 29 хувийн гүйцэтгэлтэй
15	XIV.2.14	Соёлын төвийн барилгын их засвар /Булган, Рашаант сум/	2021	2022	254.4	Барилгын их засварын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй
16		Соёлын төвийн барилгын их засвар /Булган, Хишиг-Өндөр сум/	2021	2022	350.8	Барилгын их засварын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй

Дээрх хүснэгтийн ажил эрхлээгүй 4 төсөл арга хэмжээ нь УИХ-ын гишүүний санаачилгаар төсөвт тусгагдсан бөгөөд тодруулахад түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээ хийгдсэн гэх боловч баримт материал ирүүлсэнгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ тусгасан нь хөрөнгө оруулалт, удаашрах, хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Он дамжин хэрэгжих 4 төсөл арга хэмжээний 5 ажлын гүйцэтгэл 29-90 хувийн гүйцэтгэлтэй ажлууд байна.

Б.2.2. Захиалагч, зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд арилгах арга хэмжээ авсан байна.

Аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Булган аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар эрх шилжсэн болон эрх шилжээгүй 29 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд үүнээс тоног төхөөрөмж нийлүүлэх 5, авто замын 2, цахилгаан эрчим хүчинд холбох 2 ажил байна. Үлдэх 20 нь барилга байгууламж, их засварын ажил бөгөөд барилгын ажлыг түүвэрлэн үзэхэд захиалагч, зохиогчийн зүгээс үе шатны ажлыг тухай бүр хянаж илэрсэн зөрчлийг барилга угсралтын журналын дэвтэрт хяналт хийсэн тэмдэглэл хийж, илтгэх хуудас бичдэг бөгөөд явцын хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн үүрэг даалгавраас дурдвал:

- Булган сумын 3-р цэцэрлэгийн барилгын багана, дам нурууны цутгалтын ажил гүйцэтгэх явцад орцын норм тодорхойлоогүй цутгалтыг хийж эхэлсэн тул ажлыг зогсоож, Барилгын хөгжлийн төсвийн барилгын материалын лабораторид шинжилгээг хийлгэж ажлыг үргэлжлүүлсэн.
- Бугат сумын соёлын төвийн барилгын ажлыг хүйтний нөхцөлд төмөр бетон бүтцийн ажил хийж байгаатай холбогдуулан арчилгааг сайтар хийх ба термометрийг тал бүрд байрлуулж, үзлэгийг тогтмол хийж тэмдэглэл хөтлөх, багана суурийн дээд дам нурууны арматурын зөрүүлэг, хомутны маталт, зай, алхамд анхаарч цутгахаас өмнө дам нуруу тус бүрээр акт баталгаажуулж фото зураг өвч материалд хавсаргах зэрэг үүрэг даалгаврыг өгч ажилласан байна.

Зохиогчийн хяналтыг захиалагчтай хийсэн гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилт дуусаж хүлээн авсан барилгын хувьд зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж захиалагчид ирүүлдэг бөгөөд, хэрэгжиж дуусаагүй барилгын хувьд хяналтын тайланг явцын дундуур зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, явцад илэрсэн зөрчлийг тухай бүрд засаж, залруулж байсныг тусгасан байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжийг данс бүртгэлд туссан ч эргэн төлөх нөхцөлтэйгээр олгосон тоног төхөөрөмжийг эзэнжүүлэх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд 175.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд техникийн тодорхойлолтод заасны дагуу иж бүрэн, эвдрэл гэмтэлгүй нийлүүлэгдсэн байна. Үүнд:

Хүснэгт № 6 “Тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэгдсэн эсэх”

№	Төсөл арга хэмжээний нэр, төсөвт өртөг	Төсөвт өртөг /сая.төг/	Техникийн тодорхойлолтод нийцсэн эсэх
1	Аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Булган, Булган сум/	100	Тийм
2	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/	75	Тийм
	Шинэ хөдөө төсөл /Булган/-мал угаах ванн/	406.8	Тийм
3	Шинэ хөдөө төсөл /Булган/-Өсвөр үеийн бух	98.0	Тийм

Шинэ хөдөө төсөл /Булган/-оёдлын машин	76.8	2022.05.01 дотор нийлүүлэхээр сунгасан гэрээг
Шинэ хөдөө төсөл /Булган/-Үржлийн гунж	150.0	Тийм
Шинэ хөдөө төсөл /Булган/-Хүлэмж нийлүүлэх	119.0	Тийм
Дүн	1025.6	

Нэгдсэн эмнэлэгт нийлүүлэх ходоодны уян дуранг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр, Соёлын төвийн тоног төхөөрөмжийг 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүлээн авч 7 сумын соёлын төвд хуваарилан олгосон байна.

Шинэ хөдөө төсөл 5 багцаар тендер зарлагдаж худалдан авсан 850.6 сая төгрөгийн өсвөр үеийн бух 67, хүлэмж 73, үржлийн гунж 83 толгойг хүлээн авч “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ХХК, мал угаалгын ванн 40 ширхгийг аймгийн Мал эмнэлгийн газар данс бүртгэлд тусган иргэдэд олгосон боловч эргэн төлөлтийн гэрээ байгуулж эзэнжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Б.2.4 Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон барилга, байгууламж, нийлүүлээгүй техник, тоног төхөөрөмж байхгүй байна.

Булган аймагт 2020 оноос дамжин хэрэгжсэн 6151.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 ажил хэрэгжиж байгаагаас 2 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, бусад 4 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээ сунгагдсан ажлын гүйцэтгэл 64-82 хувьтай байна.

Хэрэгжиж дуусаагүй орхигдсон барилга, байгууламж нийлүүлээгүй тоног төхөөрөмж байхгүй байна.

Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Б.3.1 Захиалагч, зохиогчийн зүгээс үе шатны ажлыг тухай бүр хянаж илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар талбайн журналд тэмдэглэн хянаж, ил ба далд ажлын гүйцэтгэлийг актаар баталгаажуулсан байна.

2021 онд эрх шилжин хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний 2 төсөл арга хэмжээнд ГХБХБГ хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тоног төхөөрөмжийн 2 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт тавьж, холбогдох газруудад комиссын актаар хүлээлгэн өгсөн байна.

Шинээр баригдаж буй эрх шилжээгүй барилга угсралт болон их засварын ажлын гүйцэтгэлд хийгдэх захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төвтэй хийсэн гэрээний дагуу аймгийн ГХБХБГ хариуцан гүйцэтгэж, хяналт хийх барилга бүр дээр мэргэжилтнүүд томилон ажилласан байна. Тус газар 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдах 6 төсөл, арга хэмжээний 7 барилга угсралт, их засвар хийгдсэн 4 төсөл, арга хэмжээний 9 нийт 16 барилгад үе шатны хяналтуудыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Их засвар, барилга угсралтын ажлын үе шатны хяналтыг аймгийн ГХБХБГ-ын барилгын хяналтын мэргэжилтнүүд үр дүнтэйгээр зохион байгуулж, барилга хариуцсан инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах ажилтан, даамал зэрэгт зөвлөгөө, даалгаврыг бүрэн өгч, барилгын гүйцэтгэлийн стандартыг хангуулан ажилласан байна.


Б.3.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь бүрэн олгосон байна.

Аймгийн ЗДТГ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж,

баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой.

Дээрх журмын дагуу өмнөх оны эрх шилжсэн 7 төсөл арга хэмжээний 3418.0 сая төгрөгийг олгохоор төсөвлөж, 3356.7 төгрөгийн олгож үүнээс 718.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Тайлант онд шинээр эрх шилжсэн 325.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж санхүүжилтийг олгосон байна.



Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан гэрээний хавсралтаар санхүүжилтийн хуваарь, анхан шатны баримт болон төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээ, баримтыг үндэслэн санхүүжилтийг олгожээ.

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад дотоодын хяналт тавих чиг үүрэг хэрэгжихгүй байна.

Төсвийн тухай хуульд Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулахаар заасан байна.

СХАА-ны аймгийн Засаг даргаар батлуулсан 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд УТХО-аар хийгдсэн ажлын үр дүнд хийх хяналт шалгалт тусгагдаагүй, УТХО-аар хийгдсэн ажлын үр дүнд хяналт шалгалт хийгээгүй байна.

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилийн санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр үр дүнтэй байна.

Б.4.1 Төлбөрийн баталгаа болон бусад үндэслэлээр ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд 6 төсөл арга хэмжээний 718.6 сая төгрөгийг байршуулан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Тухайн жилийн санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас батлагдсан санхүүжилтийн олгоогүй үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлэн авч үлдэж дараа онд бодит гүйцэтгэлээр санхүүжилтийг олгох бодлогын баримталсан нь үр дүнтэй байна.

Тухайн онд 3408.7 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 6 төсөл арга хэмжээний үлдэгдэл 643.6 сая төгрөгийг байршуулсан байна.

Хүснэгт № 7 “Төсөл арга хэмжээний барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан үлдэгдэл”

№	Төсөл арга хэмжээний нэрс	Батлагдсан төсвийн дүн /сая.төг/	Гэрээний дүн /сая.төг/	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн /сая.төг/
---	---------------------------	----------------------------------	------------------------	---

1	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	806.3	799.6	285.0
2	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/	75.0	75.0	75.0
3	Үерийн далан /Булган, Сайхан сум	431	426.8	47.7
4	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	1169.6	905	160.4
5	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	925	920	73.7
6	Шинэ хөдөө төсөл /Булган/-Оёдлын машин	76.8	76.8	76.8
Нийт дүн		3408.7	3128.2	718.6

Булган аймагт эрх шилжүүлсэн өмнөх оны 7, тайлант оны 4 төсөл, арга хэмжээнээс 2021 онд бүгд байнгын ашиглалтад орж төлөвлөсөн зорилт үр дүнг хангах ёстой. Гэтэл 2021 онд 7 нь ашиглалтад орсон буюу үр дүн 63.6 хувьтай байна.

Б.4.2 Барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгоогүй байна.

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хийгдсэн зарим ажлын үр дүнг тооцоогүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Б.5.1 Шинэ-хөдөө төслийн 2021 оны хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжийг иргэн, ААН байгууллагатай эргэн төлөлт болон ашиглалтын гэрээ хийж ажиллаагүй, бусад хэрэгжсэн төсөл арга хэмжээ зориулалтын дагуу ашиглалт хэвийн байна.

2021 онд он дамжин хэрэгжих байгаа 2 барилга бүрэн ашиглалтад орж, тоног төхөөрөмж нийлүүлэх 2, шинэ хөдөө төслийн 4 багцын ажил бүрэн дуусаж холбогдох байгууллага, иргэнд хүлээлгэн өгсөн байна.

Хүснэгт № 8 “Шинээр ашиглалтад орсон, барилга, тоног төхөөрөмж”

		Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Ашиглалт орсон огноо
1	XI.4.1.1	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	1300	2021.11.08 №22/2021
2	XIII.1.1.179	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Гурванбулаг сум/	1041.8	2021.10.06 улсын комиссын 13/2021
3	XVII.1.11	Шинэ хөдөө төсөл /Булган/-мал угаах ванн/	406.8	2021.10.05 дүгнэлт, хурлын тэмдэглэл
		Шинэ хөдөө төсөл /Булган/-Өсвөр үеийн бух	98	2021.08.04 дугаар 01,
		Шинэ хөдөө төсөл /Булган/-Үржлийн гунж	76.8	2021.09.21
		Шинэ хөдөө төсөл /Булган/-Хүлэмж нийлүүлэх	150	2021.10.18
4	XIV.3.7	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/	250	2021.12.13
5	XIX.3.24	Аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Булган, Булган сум/	100	2021.10.19 Актын дугаар 15

Шинэ-хөдөө төслийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлсэн малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр Сэлэнгэ үйлдвэрийн өсвөр насны бух 67 толгойг 98.0, үржлийн

гунж 83 толгойг 150.0, ажлыг байрыг нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хүлэмж 119.0 төгрөгөөр худалдан авч “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК хүлээн авч бүртгэлд туссан байна. 2021 оны хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжийг иргэнтэй гэрээ хийж ажиллаагүй байна.

Мөн 5 сургуулийн их засвар, 1 төсөл, арга хэмжээнд тусгасан 4 сумын эрүүл мэндийн төвийн их засварын ажил дуусаж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Б.5.2. Шинээр хэрэгжиж байгаа болон он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 2021 онд өөрчлөлт орсон ажил байхгүй байна.

Б.5.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс төлөвлөлттэй холбоотой зөрчил давтан гарсан байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитаар аймгийн ЗДТГ-т 3, Орон нутгийн өмчийн газар 1 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг аймгийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/1384 албан тоотоор ирүүлсэн байна.

Өгсөн зөвлөмжөөс шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлуудыг ТЕЗ-аас хүлээн авахдаа зураг төсөвгүй, магадлалаар баталгаажуулаагүй ажлын санал ирүүлэхгүй байхаар зөвлөмжийг хүргүүлсэн ч тайлант оны аудитаар алдаа, зөрчил давтагдсан нь УИХ-ын гишүүний санаачилгаар төсөвт тусгагдсан ажлууд байна.

Б.5.4. Улсын төсвийн санхүүжилтээр ажлын байрыг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, арга хэрэгжүүлсэн ч үр дүн хангалтгүй байна.

Шинэ хөдөө төслийн гол зорилго нь иргэдийг ажилтай орлоготой болгох, ХАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байр бий болгох, ХАА-н чадамжид суурилсан үйлдвэрлэл явуулах, хүний нөөцийг чадавхжуулах, малын чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бүрдүүлэх, эрчимжсэн аж ахуйн техник технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нэмэгдүүлэх юм.

Шинэ-хөдөө төслийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлсэн малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр Сэлэнгэ үйлдвэрийн өсвөр насны бух 67 толгойг 98.0, үржлийн гунж 83 толгойг 150.0, ажлыг байрыг нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хүлэмж 119.0 төгрөгөөр худалдан авч “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК хүлээн авч бүртгэлд туссан ч хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжийг иргэнтэй эзэнжүүлэх, ашиглалтын талаарх гэрээ хийж ажиллаагүй байна.

Шинэ-хөдөө төслийн өмнөх онуудад хийсэн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төслийн үр дүн, ашиг шимийг тооцож ажиллаагүй, ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, түрээсийн гэрээ хийсэн иргэд эргэн төлөлтөө хугацаандаа хийгээгүй, одоог хүртэл ашиглагдаагүй тоног төхөөрөмжүүд байгаа нь төсөл үр дүн багатай байна. Цаашид хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцдог, хөрөнгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх талаар ажиллах шаардлагатай байна.

Б.5.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Булган аймагт Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын ажил 2018 оноос хийгдэж одоогоор 34.8 км зам ашиглалтад орсон, мөн 2021 онд Хялганат-Хангал чиглэлийн 10 км хатуу хучилттай авто замын эхлэл, Сайхан сумын төвийн 1.7 км хатуу хучилттай авто замын ажил эхлээгүй, Бугат сумын Ханжаргалант баг, Сайхан, Хутаг-Өндөр сумын заагт орших "Дондогийн булаг" орчмыг цахилгаан эрчим хүчний системд холбох 2 ажил тусгагдсан бөгөөд он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд байна.

ДҮГНЭЛТ: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй 4 төсөл арга хэмжээг УТХО-ын жагсаалтад батлагдсантай холбоотой тухайн жилийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлсэн байна.
2. ТЭЗ-аас санал хүргүүлээгүй 4 төсөл арга хэмжээ туссан байна.
3. Төслийн саналыг холбогдох аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судалж, эрэмбэлээгүй, хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор нь үнэлээгүй, үр ашгийг тооцоолгүйгээр холбогдох салбарын Сайдад хүргүүлсэн байна.
4. 2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл батлагдаагүй байна.
5. Тендерийн баримт бичгийг худалдан авах ажлын төрөл болон худалдан авах ажиллагааны хэлбэртэй холбоотойгоор Сангийн яамнаас баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлалын дагуу бэлтгэн боловсруулж, тендерийн баримт бичгийг цаасаар болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн байна.
6. Эрх шилжсэн он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнээс гэрээг сунгасан 5 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 64-82 хувьтай байна.
7. Захиалагч, зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд арилгах арга хэмжээ авсан байна.
8. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон барилга, байгууламж, нийлүүлээгүй техник, тоног төхөөрөмж байхгүй байна.
9. ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь бүрэн олгосон байна.
10. Хөрөнгө оруулалтын үйл явцад дотоодын хяналт тавих чиг үүрэг хэрэгжихгүй байна.
11. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс төлөвлөлттэй холбоотой зөрчил давтан гарсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Нэг: Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, ХОХБТХ-ийн дарга Д.Буманбаяр нарт:

1. Аймгийн Засаг даргын СХАА-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд УТХО-ын хэрэгжилтийн явцад дотоод хяналт шалгалт хийх ажлыг тусгаж батлах.
2. Орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан, нийгэмд үзүүлэх ач холбогдлоороо нэн тэргүүний хөрөнгө оруулалтыг эрэмбэлэн Сангийн яаманд хүргүүлж байх.
3. Хөрөнгө оруулалтын цахим системийн хэрэглээг жигдрүүлж, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд бүрэн ашиглаж, эрэмбэлсэн мэдээллийг цаасаар болон цахимаар баримтжуулан авч хадгалан архивлах арга хэмжээ авах.

Хоёр. Аймгийн ОНӨГ-ийн дарга Т.Баттулгад

1. Үнэлгээний хороонд иргэд, төрийн бус байгууллагын болон мэргэжлийн байгууллагын төлөөллийг өргөн хүрээтэй оролцуулж, худалдан авах ажиллагаанд олон нийтийн зүгээс тавих хяналтыг сайжруулах, ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.